



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 дугаар сарын 08 өдөр

Дугаар 33

Хэрлэн сум

XXXII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 33 дугаар хуралдаан 2021 оны 04 дугаар сарын 08-ны өдрийн 18:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 92,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах үйл ажиллагааг хориглох тухай танилцуулах,

Цагдаагийн газар

2.Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас зарцуулах ариутгал халдваргүйтгэлгийн материалыг танилцуулах,

АЗДТГ-ын Цэргийн штаб, Эрүүл мэндийн газар

3.Тусгаарлан ажиглах байр болон гэрийн тусгаарлалтад хяналт тавих тухай тогтоолын төслийг танилцуулах тухай

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4.Буяны ажлаар ирж буй иргэдийг тусгаарлах байранд тусгаарлан ажиглах талаар санал танилцуулах,



Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Сумдын Засаг дарга, Онцгой комиссын
дарга нарт:

1.1.Аймгийн хэмжээнд “Ногоон” түвшинд байгаа сумдад согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийг дуустал 10:00-20:00 цаг хүртэл спиртийн бага агууламж /18 хувиас доош/ бүхий согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхийг зөвшөөрч бусад тохиолдолд хориглож хяналт тавьж ажиллах,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

/  /М.Бадамсүрэн
/  / Д.Баттулга

2.1.Шалган нэвтрүүлэх хөдөлгөөнт хяналтын цэгт томилогдон ажиллах Зэвсэгт хүчний албан хаагч нарт нэг удаагийн амны хаалт 1848 ширхэг, гар ариутгагч 22 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Зэвсэгт хүчний 327 дугаар ангид олгохыг зөвшөөрөв,

2.2.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал сунгасантай холбогдуулан аймгийн Шуурхай штаб, Баянтүмэн, Хөлөнбуйр, Хэрлэн сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүд 32 хоног ажиллахад шаардагдах халдвар хамгаалах хувцас /комбинзон/ 192 ширхэг, нэг удаагийн амны хаалт 13152 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Эрүүл мэндийн газарт олгохыг зөвшөөрөв,

Гурав.Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

3.1.Хүнс тээвэрлэлт хийх зөвшөөрөл авсан аж ахуй нэгж байгууллагуудын ачаа буулгалтад тухайн байгууллагаар хариуцлага хүлээлгэх, ачаа тээвэрлэлтийн түгээлт хийх цэгийг судалж аймгийн Шуурхай штабын дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.2."Тусгаарлан ажиглах байр болон гэрийн тусгаарлалтад хяналт тавих тухай" аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж баталгаажуулах,

Дөрөв.Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-д:

4.1.Буяны ажилд оролцохоор ирж буй иргэдийг тусгаарлах байранд тусгаарлах тухай журам боловсруулж баталгаажуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА

М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА

